

СОНИНУУДЫН НИЙТЛЭЛИЙН БОДЛОГО БА
МАНАЙ НИЙГМИЙН ҮНЭТ ЗҮЙЛС

Б. Тогтохбаяр*

* МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмийн докторант

Түлхүүр үг: сонины нийтлэлийн бодлого, олон нийтийн санаа бодолд ОНМХ-ийн үзүүлж буй нөлөө, нийгмийн үнэт зүйлс.

Монгол орон ардчилалд хөл тавьснаас хойшх арван таван жилд нээлттэй нийгэм дэх өөрийн шинэ үнэт зүйлсээ бий болгох, уламжлалаа сэргээх үйл явц үргэлжилсээр байна. Манай нийгмийн үнэт зүйлс хэвлэл мэдээллийн гол хэрэгслийн нэг болсон сонинуудын нийтлэл, мэдээ мэдээллийн сэдэвт хэрхэн тусгагдаж байгаа нь сонирхол татаж байгаа юм.

ОНМХ нь нийгмийн санаа бодол, олон нийтийн ухамсрыг бүрдүүлэн төлөвшүүлж байдаг. Түүний дундаас сонин нь мэдээллийн бусад хэрэгслийг бодвол нийгмийн хамгийн боловсролтой хэсэгт нөлөөлдөг. Учир нь:

- Сониныг заавал бичиг үсгийн боловсролтой хүлээн авагч уншиж, мэдээлэл авдаг.

- Радио, телевиз, FM радиотой харьцуулбал уншигч ганцаараа бие даасан байдалд сонин уншиж мэдээлэлд өөрийн гэсэн үнэлэлт дүгнэлт

өгөх боломжтой байдаг зэргээр бусад мэдээллийн хэрэгслээс онцлог байдаг байна. Түүнчлэн сонин нь үйл явдал баримтыг зөвхөн олон нийтэд мэдээлээд зогсохгүй, нийтлэлийн бодлогоороо дамжуулан түүний учир шалтгаан, үр дагавар, хэтийн төлөвийг нь тодорхойлон задлан шинжлэх боломжтой хүчирхэг хэрэгсэл билээ.

Ийнхүү өнөөдрийн Монголын сонинуудын нийтлэлийн бодлого, мэдээ мэдээллийн сэдвийг судлахдаа өдөр тутмын сонинуудаас “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, долоо, арав хоног тутмынхаас “Сэрүүлэг”, “Хүмүүс” зэрэг хамгийн олон уншигч, захиалагчтай дөрвөн сониныг төлөөлүүлэн сонгож, энэ оны ес, арав, арваннэгдүгээр сарын дугааруудаас нь түүвэрлэн авч үзсэн юм.

Судалгаанаас үзэхэд “Өдрийн сонин”-д нийтлэгдэж буй мэдээ, мэдээллийн 26.2 хувийг улс төрийн сэдэвт нийтлэл эзэлж байна. Энэ нь гэмт хэрэг 6%, урлаг соёл 12%, эдийн засаг, санхүү бизнес 8.3%, реклам сурталчилгааны зорилготой нийтлэл 10%, спорт 4%, нийгмийн амьдрал 5%, олон улсын мэдээ 20.1%-ийг эзэлж

байгаатай харьцуулбал маш их тоо юм. Харин түүх 2.7%, уламжлал 1.1%, хэвлэлийн эрх чөлөө 2.7%, хөдөө аж ахуй 2%-ийг эзэлж, шинжлэх ухаан танин мэдэхүй, ёс суртахуун, эрүүл мэнд, эрүүл аж төрөх ёс, гэр бүл, хүйсийн тэгш эрх, хүний эрх, эрх чөлөө, тусгаар тогтнол, батлан хамгаалах, хууль ёс, боловсрол, шашин зэрэг нийгмийн үнэт зүйлсийн бүрдэлд томоохон байр суурь эзэлдэг сэдвүүд хоёр сонины нийтлэлийн бодлогод маш өчүүхэн хувийг буюу нийтдээ 6.5% эзэлж байна.

Харин "Өнөөдөр" сонины хувьд нийт мэдээ, мэдээллийнх нь 22%-ийг улс төрийн сэдэв эзэлж байна. Манай анхны хувийн өдөр тутмын чөлөөт сонины хувьд "Өнөөдөр" сонин бусад өдөр тутмын сонинтой

харьцуулахад улс төржилтийн хувь арай бага, харин урлаг соёл, байгаль зоологи, эдийн засаг, спортын сэдэвт нийтлэлийн бодлогоо илүү хандуулдаг хандлага ажиглагдсан юм. Тухайлбал тус сонины нийтлэлийн 14.5%-ийг урлаг соёл, уран зохиол, эдийн засаг, санхүү, бизнес 9.5%, гэмт хэрэг 7.5%, олон улсын мэдээ 19.5%, спорт 6.9%, түүх, уламжлал 2.8%, реклам сурталчилгааны нийтлэл 8.5%-ийг эзэлж байв. Манай өдөр тутмын энэ хоёр том сониныг харьцуулах юм бол улс төрийн сэдэв, шуурхай, дуулиант мэдээллээрээ "Өдрийн сонин" нь илүү байхад, урлаг, соёл, спорт, эдийн засгийн сэдэвт "Өнөөдөр" илүү ач холбогдол

өгдөг нь уг судалгаагаар харагдсан юм. Түүнчлэн өнөөгийн нийгмийн амьдралыг авч яваа эгэл жирийн иргэдийн санаа бодол, ахуй амьдралаа дээшлүүлэх бүтээлч санаачилгыг тусгасан нийтлэл, цаг үеийн дуулиант мэдээллийг шуурхай хүргэх хурдаараа "Өдрийн сонин" нь "Өнөөдөр"-өөс ялгарч байлаа. Түүнчлэн ОНМХ нь цаг үеийнхээ тусгал болж байдгийн хувьд өнөөдрийн Монголын нийгмийн амьдралд болж байгаа зарим томоохон үйл

явдлуудын нөлөөлөл ч ажиглагдаж байв. Тухайлбал хэвлэлийн эрх чөлөө, батлан хамгаалах, түүх, үндэсний бахархлыг хөндсөн нийтлэл дээрх хоёр сонины энэ оны нийт дугааруудад урьд жилүүдийнхээс харьцангуй илүү гарах болсон нь олон нийтийн

«
Түүнчлэн ОНМХ нь цаг үеийнхээ тусгал болж байдгийн хувьд өнөөдрийн Монголын нийгмийн амьдралд болж байгаа зарим томоохон үйл явдлуудын нөлөөлөл ч ажиглагдаж байв.

»

радио, телевизийн хуулийг хэрэгжүүлэх болсон, ирэх жил Их Монгол улсын тулгар төрийн 800 жилийн ой тохиож байгаа, Монгол Улс Иракт энхийг сахиулах үйлсэд цэргээ илгээх болсон зэрэг үйл явдлуудтай холбоотой ажээ. Харин өнөөгийн Монголын мэргэжлийн сэтгүүл зүйн нүүр царай болж, Хэвлэлийн хүрээлэнгийн мониторингийн судалгаагаар хот, хөдөөгийн хамгийн олон уншигч, захиалагчтай сонины тоонд орсоор байгаа энэ хоёр сонины нийтлэлийн сэдвийн 24.1%-ийг улс төр эзэлж байгаа нь өнөөдрийн Монголын нийгмийн амьдрал улс төрөөс хэт хамааралтай, үүнээс үүдээд сэтгүүл зүй хэмжээнээсээ илүү

улстөржсөний шууд илрэл болж харагдаж байгаа юм. Мөн уг хоёр сонины нийтлэлийн бодлогод дунджаар 13% буюу багагүй хувь эзэлж буй урлаг соёлын сэдвийг дотор нь ангилж үзвэл үүний 4 орчим хувь нь зохиолын гэж нэрлэгдээд буй нийтийн дууг тойрсон байхад 3 орчим хувь нь рок попын тухай байхад ардын болоод сонгодог урлаг дөнгөж 2 хувийг нь эзэлж байв.

Монголын хэвлэлийн хүрээлэнгийн мониторингийн судалгаагаар хөдөөгийн хүн амын дунд өдөр тутмын сонинуудыг урдаа оруулдаггүй байнга уншигч, захиалагчаараа тэргүүлж байдаг хэвлэлүүд бол "Сэрүүлэг", "Хүмүүс" сонинууд билээ. Энэ хоёр сонины нийтлэл, мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийх нь өнөөдрийн дундаж монгол хүний, цаашлаад олон нийтийн сонирхол, хэрэгцээ, үнэт зүйлс, үнэлэмжийг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Учир нь чөлөөт хэвлэл үүсч, хөгжсөн сүүлийн арав гаруй жилийн явцад ОНМХ-ийн мэдээллийн сонголт, боловсруулалт нь уншигчийн эрэлт, хэрэгцээ, сонирхолд үйлчлэх болсон билээ. Дээрх хоёр сонины нийтлэл, мэдээллийн сэдвийг ажиглахад өдөр тутмын сонинуудаас илүү улстөрждөг нь "Сэрүүлэг"-ийн нийтлэлийн сэдвийн 46.5, "Хүмүүс"-ийн 48.8%-ийг зөвхөн улс төрийн сэдэв эзэлж байгаагаас харагдаж байна. Энэ нь "шар" гэгддэг сонинууд улс төрийн сэдэвт 2-3 нүүрээ зориулдаг гадна УИХ-ын гишүүд, сайд нар, улстөрчдийн хувийн амьдралыг тойрсон элдэв албан бус эх сурвалжийн жижиг мэдээлэл олноор нь нийтэлдэгтэй холбоотой юм. "Сэрүүлэг" сонинд нийтлэгдэж буй мэдээллийн 7 орчим хувийг гэмт хэрэг, урлаг соёл 6%,

үүний тал хувь нь нийтийн дуу, 14.5% нь реклам сурталчилгааны зорилготой материал, 4.6%-ийг нийгмийн амьдрал, ядуурал, үлдсэн 21.4%-ийг урлаг, спортын одод, томоохон бизнесменүүд, алдартнуудын хувийн бизнесменүүд, тойрсон мэдээлэл эзэлж байна.

"Хүмүүс" сонины хувьд нийт мэдээ мэдээллийн 6.8% нь гэмт хэрэг, урлаг соёл 5.4%, реклам сурталчилгааны төлбөрт нийтлэл харьцангуй бага 8%, олон улсын мэдээ 18.4%, алдартнуудын хувийн амьдрал 11%, бусад сэдэв 1.6%-ийг эзэлж байлаа. Уг хоёр сониныг нийтлэлийн бодлогын сонин харьцуулахад "Хүмүүс" сонинд гадаад ертөнцийн мэдээлэл нийт мэдээллийн дунд багагүй хувийг эзэлдэг байхад, "Сэрүүлэг" алдартнуудын хувийн амьдрал, төлбөрт материал илүү нийтэлдгээс бусдаараа нийтлэлийн бодлогын хувьд ойролцоо дүр зураг харагдаж байв. Эдгээр сонины нийтлэлийн бусад сэдвийн 50 хувийг шашин, зурхай, мухар сүсгийн агуулгатай мэдээлэл эзэлж байгаа нь бас нэг анхаарал татсан асуудал байв.

Ер нь цэвэр арилжааны зорилгоор уншигчдын эрэлт, хэрэгцээ, сонирхолд үйлчлэх зорилгоор мэдээллээ бэлтгэдэг эдгээр сонины хувьд нийтлэлийн бодлого нь туйлын явцуу, улстөрчид, намуудын амьдрал, урлаг, спортын оддын хувийн амьдрал, гэмт хэрэг, дуулиант үйл явдлын хүрээнд эргэлдэж байна. Түүнчлэн дээрх хоёр сонины нэг удаагийн дугаарт нийтлэгдэж буй мэдээллийн гол баатрууд нь хэн байв гэдгийг ажиглахад дунджаар 20-25 улс төрчийн нэр дурдагддаг бөгөөд мисс, загвар өмсөгч, бөх нэгээс доошгүй, рок попын дуучин 4-5, зохиолын дуучин 4-

6, хошин шогийн болон кино, драмын жүжигчин 3-4, бизнесмен 1-2, яруу найрагч болон бусад алдартан 1-2 хүний тухай бичдэг байна.

Өдөр тутмын болон "шар" сонины байнгын баатар болсон 30 орчим, үе үе бичигдэж байдаг нийт 90-100 улс төрч байгааг Ерөнхий сайд Ц.Элбэгдорж, Ерөнхийлөгч Н.Энхбаяр, УИХ-ын гишүүн Л.Гүндалай, МАХН-ын дарга М.Энхболд, спикер Ц.Нямдорж нар тэргүүлж, МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга С.Баяр, УИХ-ын гишүүн З.Энхболд, Р.Гончигдорж, М.Энхсайхан, Д.Лүндээжанцан, Н.Баяртсайхан, Л.Одончимэд, С.Ламбаа, "Симба" Батаа, Б.Жаргалсайхан, М.Энхсайхан, С.Оюун, "Женко" Баттулга, Э.Бат-Үүл, Ц.Шаравдорж, У.Барсболд, Н.Алтанхуяг, Н.Батбаяр, Г.Батхүү, У.Хүрэлсүх, Т.Ганди, С.Баярцогт, О.Энхсайхан, Б.Эрдэнэбат, Д.Идэвхтэн, Д.Арвин болон Д.Туяа, Б.Мөнхтуяа, Су.Батболд, Сү.Батболд, П.Цагаан, Д.Дорлигжав, Ө.Энхтүвшин, Ё.Отгонбаяр нарын улс төрчид удаалж байна. Урлаг соёлынхны дотроос дуучин С.Жавхлан, Баясгалан, Чинболор, Бат-Эрдэнэ, "Камертон", "Хурд", "Татар" хамтлагийнхан, Энхзул, Эрдэнэцэцэг, АЖ А.Долгор, дуучин Үүрцайх, Оюумаа нар хэвлэлээр байнга бичигддэг хүмүүсийг тэргүүлж, Аварга Дагвадорж, аварга Г.Өсөхбаяр, дуучин МУГЖ Т.Ариунаа, жүжигчин МУГЖ Д.Сосорбарам, хошин шогийн жүжигчин С.Өлзийхүү, Хүрлээ, Амбий, Бооёо, Аглуу, С.Онон, Одончимэг, аварга А.Сүхбат, мисс Ч.Содтуяа, загвар өмсөгч Одгэрэл, Д.Болормаа, хамба лам Д.Чойжамц, бурханч лам Г.Пүрэвбат, Д.Болормаа, бизнесмен С.Болдхэт, Ц.Мянганбаяр,

Г.Алтан, Буяндорж, Жамьянсүрэн, улирлын чанартайгаар үе үе гарч ирдэг уяач, бөхчүүд тэдний гэргий нарын зэрэг урлаг соёл, спортын алдартан 60-80 хүн хэвлэлийнхний анхааралд байдаг байна. Харин шинжлэх ухаан, технологийн салбар, иргэний нийгэм, сонгодог урлаг, эдийн засаг, улс төрийн мэргэшсэн судлаачид, хүмүүнлэгийн ухаан, сэхээтний томоохон төлөөллөөс хэвлэл мэдээллийн байнгын анхааралд байж, жинтэй үгээ хэлж олон нийтийн санаа бодолд нөлөөлж байдаг оюунлаг хэсгийн баатрууд ховор байгаа нь эндээс харагдсан юм. Түүнчлэн одоогоос хоёр жилийн өмнөхтэй харьцуулахад урлаг соёлын мэдээлэлд рок поп хүчтэй байр эзэлж, оддын мэдээллийн гол баатар нь МУГЖ Т.Ариунаа, МУГЖ Б.Сарантуяа, дуучин С.Сэрчмаа нар байсан бол өнөөдөр зохиолын дуучид тэдний байрыг эзэлж, улс төрчдийн дунд нийгэмд бий болоод буй янз бүрийн эвсэл хөдөлгөөний удирдагчид нэмэгдэн орж иржээ.

Дээрх дөрвөн сониноос "Өнөөдөр", "Хүмүүс" сониноор төлөөлүүлэн нэг удаагийн дугаартаа ямар мэдээллийг онцолсныг авч үзье.

"Өнөөдөр", 2005, №255:

- Цэвэгийн Байды цэцгэн Байды боллоо
 - Элбэгээ символдов
 - Намын даргын суганаас хотын дарга тодорлоо
 - Рамсфельд монголчуудтай мэндчилэв
 - "Алтан үеийнхэн" 60 жил үерхсэн найзууд
- №251:
- НҮБ тансаг хорооллоос тайгын урцанд хүрэх ёстой

- Шувууны ханиад 50 сая хүний аминд хүрч болзошгүй
- Хэнтий аймагт хорлон сүйтгэх ажиллагаа болов уу?
- Нийтийн тээврийн хэрэгслийг дахин үзлэгт орууллаа

№246:

- Америкийн том зочид шил даран ирнэ

- С.Батдэлгэрийг томилох нь
- Хэсгийн төлөөлөгч малын хулгайчийн аминд хүрчээ

- Вьетнам эрд 5 жил хорих ял оноолоо

- Хүүхдүүд нэгийгээ хутгалжээ

№236:

- Төрийн өргөн ёслол хүндэтгэлийн цогцолборын шавыг тавилаа

- Асашёорюү хүүтэй болов

- Морин хуурт зориулсан шилдэг бүтээлүүд амилна

- Америкийн хорихоос хятад хоригдол оргожээ

"Хүмүүс":

2005, №39:

- Далай аварга Г.Өсөхбаярын цолыг МУ-ын төр гавьяаар мялааж, "Бриж" групп "Seiko"-ийн алтан цаг, 18 сая төгрөг бэлэглэлээ

- "Монголросцветмет"-ын Х.Бадасүрэнгийн гэргий Ж.Рэнцэн-Амгалан: Ханийхаа 50 насыг хүндэтгээд сая гаруй төгрөгөөр авсан ижил цоохор морь бэлэглэсэн

- Жүжигчин Б.Эрдэнэчимэг: Дамдинбазар надад тохирох эр биш учир салсан

- УИХ-ын гишүүн, ЗТАЖ-ын сайд Г.Батхүү: АН бүлэггүй болсноор ЗГ огцорно гэдэг суудал горьдогчдын биелшгүй санаа

- Дуучин Ч.Бат-Эддэнэ: Би охидыг машинаар үнэлж унтах задарсан баян биш

- Төрсөн үрийнхээ хүзүүг заазуураар хэрчиж алчихаад нойлын утсаар хүзүү толгойг нь залгаж оёжээ

№38:

- Японы нөлөө бүхий бизнесмен Монголын ашигт малтмалын 281 ордыг эзэмшилдээ авсан

- С.Жамьянсүрэн: Нэг ч төгрөггүй хүн яаж хөл дээрээ босдогийг миний ард түмэн хараарай

- Хийлч Дэлгэрцэцэгийн нүглийг ариусгаж Гандан хийдийн лам нар бүхэл шөнийн турш ном хуржээ

- УИХ-ын гишүүн Н.Баяртсайхан: АА-н нэгийг ялгалгүй ижил татвар авч хөнгөлөлт үзүүлнэ

- УИХ-ын гишүүн Ж.Наранцацралт: АН арчаагүйгээсээ болж МАХН-аар хангалттай тоглуулсан

- МУГЖ Б.Сарантуяа шинэ хайртай учирчээ

- Дуучин Минжинсорын заавраар мэс засалд орсон бүсгүйчүүд нүд хамаргүй боллоо

- "Шинэ үе" хамтлагийн Бооёо: Хамт олон хэдэн ч хүнээр дутдаггүй

- Төрийн мэдлийн радио, телевиз олон нийтэд 100 хувь шилжлээ

№34:

- МУ-ын Ерөнхийлөгч Н.Энхбаяр, УИХ-ын гишүүн М.Энхболдын хүүхдүүд Гачуурт тосгоны залуучуудыг нэвширтэл зодож танхайрлаа

- Б.Батгэрэл: Амьдралын баталгаагүй хуримын инж даах чадваргүй солонгос эрчүүд монголоос хямдхан эхнэр авч байна

- Зуучлах товчооны дарга Сүхбаатарыг зайлуулах хорыг сайдууд гардан хийж эхэллээ

- ХХАА-н сайд асан Д.Насанжаргал Хятадад хориглосон эмийг хилээр оруулжээ

- Мисс Д.Пүрэвсүрэн: Би shopping хийх гэж л гадаад руу явдаг

Эндээс үзэхэд өдөр тутмын сонин цаг үеийн шуурхай мэдээлэл, улс төр, гадаад ертөнцийн дуулиант үйл явдал зэрэгт анхаарлаа илүү хандуулдаг байхад "шар" сонин урлаг, спорт, бизнесийн алдартнуудын хувийн амьдрал, гэр бүлийн зөрчил, хов жив, өмч хөрөнгийг нь онцлон сонирхож, улс төрийн амьдралыг зөвхөн лидерүүд, намуудын зөрчил, хагарал, улстөрчдийн хувийн үзэл бодлын талаас нь авч үзэн, гэмт хэргийг хэрцгий үйлдлийнх талаас онцлон бичдэг байна. Энд "Хүмүүс" сониноос жишээ болгон авсан цөөхөн дугаараас үзэхэд эмэгтэйчүүд ихэвчлэн хэвлэлд сөрөг талын баатрууд болж байдаг нь "Хийлч Дэлгэрцэцэгийн нүглийг арилгах гэж Гандангийн лам нар шөнөжин ном хуржээ", "Минжинсорын заавраар мэс засалд орсон хүүхнүүд нүд, хамаргүй болов", "Жүжигчин Эрдэнэчимэг: Дамдинбазар надад тохирох эр биш тул салсан", "Мисс Пүрэвсүрэн shopping хийх гэж л гадаад явдаг" гэсэн материалуудаас харагдаж байгаа юм.

Энд "Хүмүүс" сониноос жишээ болгон авсан цөөхөн дугаараас үзэхэд эмэгтэйчүүд ихэвчлэн хэвлэлд сөрөг талын баатрууд болж байдаг нь "Хийлч Дэлгэрцэцэгийн нүглийг арилгах гэж Гандангийн лам нар шөнөжин ном хуржээ", "Минжинсорын заавраар мэс засалд орсон хүүхнүүд нүд, хамаргүй болов", "Жүжигчин Эрдэнэчимэг: Дамдинбазар надад тохирох эр биш тул салсан", "Мисс Пүрэвсүрэн shopping хийх гэж л гадаад явдаг" гэсэн материалуудаас харагдаж байгаа юм.

шинж бий болгодог онцгой төрлийн харилцаа бол үнэт зүйлс билээ. Ард түмэн, үндэстэн бүхэн нийгмийн хөгжлийн шат бүхэндээ тохирсон өөрийн үнэт зүйлс, өөрийн соёлтой байж, түүгээрээ бусад ард түмнээс ялгарч байдаг. ОНМХ нь уншигч, үзэгчдийнхээ эрэлт, хэрэгцээ, сонирхолд үйлчилж, тэр хэрээрээ олон нийтийн санаа бодлыг бүрэлдүүлэн төлөвшүүлж байдаг институци билээ. Олон нийт юу уншиж, юуг илүү сонирхож байгаагаар нь өнөөдрийн Монголын нийгмийн үнэт зүйлсийг тодорхойлох зам бол манай нийгэмд шашин мухар сүсгийн

техник, технологийн дэвшил, ёс суртахуун, гэр бүл, хүйсийн тэгш эрх, хүний эрх, гүн ухааны үзэл баримтлал, уран зохиолын талаарх нийгмийн оюунлаг давхаргынхны санаа бодол, манай нийгмийн үнэт зүйлсийн г хөндсөн сэдэв төдийлөн жинтэй байр эзэлдэггүй ажээ. Харин ч тэдгээрийн нийтлэлийн бодлогыг бараг л улс төр тодорхойлж байгаа нь Монголын нийгэм улс төрөөс хэт хамааралтай, олон нийт нь ирээдүйн амьдралаа төрд даатган, бэлэнчлэх сэтгэл зүй даамжирсаар байгаагийн нэгэн илэрхийлэл юм. Бодгаль, нийгмийн бүлгүүдийн ашиг сонирхол, хэрэгцээг эд материал, оюуны үзэгдлүүдийн ертөнцөд илэрхийлж, материаллаг бус хэлбэрээр нийгмийн тодорхой

«

Ер нь өдөр тутмын болон долоо, арав хоног тутмын сонинуудын нийтлэлийн бодлогод үндэсний бахархал, техник, технологийн дэвшил, ёс суртахуун, гэр бүл, хүйсийн тэгш эрх, хүний эрх, гүн ухааны үзэл баримтлал, манай нийгмийн үнэт зүйлсийн г хөндсөн сэдэв төдийлөн жинтэй байр эзэлдэггүй ажээ.

»

шинж бий болгодог онцгой төрлийн харилцаа бол үнэт зүйлс билээ. Ард түмэн, үндэстэн бүхэн нийгмийн хөгжлийн шат бүхэндээ тохирсон өөрийн үнэт зүйлс, өөрийн соёлтой байж, түүгээрээ бусад ард түмнээс ялгарч байдаг. ОНМХ нь уншигч, үзэгчдийнхээ эрэлт, хэрэгцээ, сонирхолд үйлчилж, тэр хэрээрээ олон нийтийн санаа бодлыг бүрэлдүүлэн төлөвшүүлж байдаг институци билээ. Олон нийт юу уншиж, юуг илүү сонирхож байгаагаар нь өнөөдрийн Монголын нийгмийн үнэт зүйлсийг тодорхойлох зам бол манай нийгэмд шашин мухар сүсгийн

хэлбэрээр сэргэн, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, спортоос илүү нийтийн дуу, хошин урлаг цэцэглэн хөгжиж, иргэд амьдралын асуудлаа өөрийн бүтээл санаачилга, оролцооноос илүү улс төрчид, төр засагт даатган, бэлэнчилж, хэт улстөрждөг, манай нийгмийн баатрууд нь улстөрчид, бөхчүүд, хошин шогийн жүжигчид, нийтийн дуу, рок попын дуучид, бөхчүүд, гоо бүсгүй, загвар өмсөгчид, томоохон лам нар байдаг, уран зохиол, ном, үндэсний кино урлаг, оюунлаг ертөнц, гэр бүл, үндэсний сэргэн мандалт, эх оронч үзэл зэрэг үнэт зүйлс хэвлэл мэдээлэл, олон нийтийн санаа бодолд жинтэй байр суурь эзэлдэггүй ажээ.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. З у л ь к а ф и л ь М. 1998. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ.

2. 2005. "Монголын хэвлэл мэдээлэл-2004" Монголын хэвлэл мэдээллийн мониторинг. УБ.
3. Б о л д - Э р д э н э Б. 1999. Нийгэм, улс төр, хэвлэл мэдээлэл. УБ.,
4. Х а н т и н г т о н П. С. 2005. Иргэншил хоорондын мөргөлдөөн. Шинэчдэгдэн буй дэлхийн дэг журам. УБ.
5. Г а л и н д э в Б., Б а т ж а р г а л Г. 2001. Орчин үе, онол, оюутан. УБ.

Resume

In this article, the writer has given evaluation and conclusion after observing topics of news and information printed in the biggest newspapers of Mongolia. In order to do this, the writer has chosen 2 the most popular daily newspapers and 2 yellow papers for research. As a result of research, the writer concluded the popular topics written in Mongolian newspapers are related to the social values.